



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/570

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 29.1.4-ийн “в” дэх заалт, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хан-Алтай ресурс” ХХК-ийн нийгмийн хариуцлагын хүрээнд Есөнбулаг, Бигэр, Дэлгэр сумдын нутагт тавигдсан түрж тэгшлэн сайжруулсан автозамын ажлын явцтай танилцаж, үнэлэлт өгөх, хамгаалалтын зураглал гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Мөнхцэцэг

(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Б.Бямбадорж -(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, Ерөнхий архитектор)

Д.Мөнгөнчимэг-(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт хамгаалалт, нөхөн сэргээлт, байгаль орчинд, нөлөөлөх байдлын үнэлгээ, цөлжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Г.Болд-Эрдэнэ-(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Г.Мөнхөө -(Мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын улсын байцаагч)

0201001970

2.

Б.Батбилэг -(Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн зохицуулагч, цагдаагийн дэслэгч)

А.Алтанхуяг -(Есөнбулаг сумын Засаг дарга)


Г.Баасанмаа -(Дэлгэр сумын Засаг дарга)

Д.Батмөнх -(Бигэр сумын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:З.Жаргалтуяа -(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн)

2.Бигэр, Дэлгэр, Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт хийгдсэн орон нутгийн чанартай сайжруулсан автозамын трассын болон хамгаалалтын зурвасын координатын зураглал, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг гаргаж үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Ж.Мөнхцэцэг)-т даалгасгай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ